



МОНГОЛ УЛС
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧИЙН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/41


Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Дотоодын цэргийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2.Дүрмийг алба хаагчдаар судлуулан, үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллахыг штаб, анги, тусгай салбарын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоодын цэргийн штаб (бригадын генерал Р.Чингис)-т даалгасугай.
- 4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

КОМАНДЛАГЧ,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.СҮХБОЛД

Дотоодын цэргийн командлагчийн
2014 оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дотоодын цэргийн алба хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлж, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гарахаас сэргийлэх, хяналт тавих, ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Дотоодын цэргийн алба хаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Дотоодын цэргийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтална.

1.3.Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм нь Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Цэргийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон Цэргийн нийтлэг дүрмүүд, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актад тусгагдсан хэм хэмжээ, энэхүү дүрмээс бүрдэнэ.

1.4.Энэхүү дүрмийг алба хаагч үйл ажиллагаандаа мөрдлөг болгон албаны нэр хүнд, алба хаагчийн ёс зүйг эрхэмлэн дээдэлж, сахин биелүүлнэ.

1.5.Дотоодын цэргийн алба хаагч Төрийн албаны тухай, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дотоодын цэргийн тухай хуульд заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална. Үүнд:

1.5.1.хууль дээдлэх;

1.5.2.шударга байх;

1.5.3.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

1.5.4.хариуцлагатай байх;

1.5.5.манлайлах, хамтач байх.

1.6.Энэхүү дүрэм нь Дотоодын цэргийн офицер, ахлагч, дадлагажих ажилтан, хугацаат цэрэг, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй болон гадаад, дотоодын сургууль, дамжаанд суралцаж буй алба хаагчдад үйлчилнэ.

Хоёр.Ёс зүйн хэм хэмжээ

2.1.Дотоодын цэргийн алба хаагч нь хууль дээдлэх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

2.1.1.өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёслон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлан ажиллах;

2.1.2.дотоодын цэргийн байгууллагын нэр хүнд, олон нийтийн итгэл нь алба хаагч нэг бүрээс шууд шалтгаална гэдгийг байнга анхаарч, албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

2.1.3.төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг буюу хувийн мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад санаатай эсхүл болгоомжгүйгээр задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэхгүй байх;

2.1.4.албан ажилд шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулахгүй байх, удирдлагыг бодитой, хуульд нийцсэн, үнэн зөв мэдээллийн шуурхай хангах;

2.1.5.нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс зүй, зан суртахууны хэм хэмжээг болон дотоодын цэргийн үйл ажиллагааны журмыг сахин мөрдөх;

2.1.6.хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад ажил, хөдөлмөр эрхлэхгүй байх.

2.2.Дотоодын цэргийн алба хаагч нь шударга ёсны зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.2.1.алба хаагч нь хувийн болон нийгмийн амьдралдаа нэр төртэй, үнэнч, зарчимч, хүндлэл төрүүлэхүйц байдлыг эрхэмлэж байх;

2.2.2.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусадтай эелдэг, ажил хэрэгч, хүлээцтэй, хүндэтгэлтэй, адил тэгш харьцаж, тэдний нэр төр, алдар хүнд хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.2.3.дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусдын эрхэнд хууль бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргахгүй байх;

2.2.4.хууль бус аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байх бөгөөд албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, аливаа нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

2.2.5.албан тушаал, хуулиар олгогдсон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглахгүй байх, бусдад давуу байдал бий болгох, үгсэн тохирох, амлалт өгөх, шан харамж авах, үйлчилгээ, зээл авах, ийнхүү авахаар шахаж шаардах, ятгах, бусдад зуучлах, хуульд харш болзол тавих, бусдын өмч хөрөнгийг хувийн болон албан ажилд ашиглахгүй байх;

2.2.6.хамтран ажиллаж байгаа байгууллага, иргэн, хуулийн этгээд, алба хаагчийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлөхгүй, харьяаллын бус үйл ажиллагаанд оролцохгүй байх;

2.2.7.улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байж, тэдгээрийн зохион байгуулсан үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох, бусдыг татан оролцуулах, оролцох санал тавихгүй байх;

2.2.8.бусад алба хаагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байж, хууль бус хүсэлт тавих, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

2.3.Дотоодын цэргийн алба хаагч нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.3.1.хүнийг үндэс угсаа, хэл арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхгүй байх;

2.3.2.хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэж, хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх;

2.3.3.хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусадтай зөв боловсон эелдэг, хүлээцтэй, тэвчээртэй, ажил хэрэгч, зарчимч харьцах бөгөөд бусдын эрхэнд хууль бусаар халдах, өөрийн байр суурийг бусдад тулгах, доромжлох, далайлган сүрдүүлэх, чирэгдүүлэх, хүнд суртал гаргах, бусдыг үл тоомсорлох, хууран мэхлэх зэрэг аливаа зохисгүй үг, үйлдэл гаргахгүй байх;

2.3.4.алба хаагч нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх зэрэг үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

2.4.Дотоодын цэргийн алба хаагч нь хариуцлагатай байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

2.4.1.өөрийн болон албаны нэр төрийг ариун байлгах, иргэд, хамгаалуулагч байгууллагын ажилтан, алба хаагчтай соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцах, үл тоох, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргахгүй байх;

2.4.2.хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа асуудалд нухацтай хандаж, өөртөө өндөр шаардлага тавьж, эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх;

2.4.3.байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмээг зохион байгуулж, оролцохгүй байх;

2.4.4.албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

2.4.5.мөрийтэй, бооцоот тоглоом болох хуулиар хориглосон тоглоом тоглох, зохион байгуулахад оролцохгүй байх;

2.4.6.ажлын байранд, ажлын цагаар, албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон дүрэмт хувцастай согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэхгүй, хуулиар хориглосон газар тамхи татахгүй байх, олон нийтийн газарт нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахих;

2.4.7.замын хөдөлгөөний дүрмийг чанд баримталж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

2.4.8.гэр бүл, үр хүүхдэдээ халамж анхааралтай байж, тэдний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдахгүй байж, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахин биелүүлэх;

2.4.9.олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албаны мэдээ, мэдээлэл оруулахгүй байх, хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцахдаа төвийг сахисан байдлыг хангаж, хувийн итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандах;

2.4.10.дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник, хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй, үрэгдүүлэхгүй, хууль бусаар хэрэглэх, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

2.4.11.амралт, чөлөө, томилолтоор яваа алба хаагч хүндэтгэх шалтгаанаар өөрийн анги, байгууллагад хугацаандаа очиж чадахгүйд хүрвэл саатсан шалтгааныг харьяалах анги, байгууллагын захирагч /дарга/-д нэн даруй мэдэгдэх;

2.4.12.байгууллагын үйл ажиллагааг мушгин гуйвуулах, хамт олны эв нэгдлийг бутаргах, үндэслэлгүйгээр гүтгэх, нэр хоч өгөхийг цээрлэх;

2.4.13.гадаад улсад албан томилолтоор ажиллахдаа дипломат ёс жаягийг чанд баримтлан Монгол Улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

2.4.14.өөрийн шийдвэр, үйл ажиллагааны үр дагаврыг бүрэн хариуцаж, албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээх;

2.4.15.өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй ажил, үүрэг гүйцэтгэх тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэж, хөдөлмөр, хамгааллын аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг чанд сахих;

2.5.Дотоодын цэргийн алба хаагч нь манлайлах, хамтач байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

2.5.1.байгууллагын соёл, дэг журам, албаны харилцааны ёс зүйг чанд сахиж, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан, олон нийтийн итгэлийг алдагдуулахуйц аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтийн дунд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;

2.5.2.өөрийгөө тогтмол хөгжүүлж, багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албаны тушаалтны итгэлийг дааж ажиллах;

2.5.3.удирдах албан тушаалтан бусдын ажил хэрэгч саналыг хүлээн авч шийдвэрлэн, ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлж байна;

2.5.4.бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

2.5.5.удирдлагын зохих шийдвэргүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил таслах, ажлын байр, хариуцсан ажил, үүргээ дур мэдэн орхих, шатар даргын зөвшөөрөлгүйгээр тухайн орон нутгийн бүсээс гарах, хууль журмын хүрээнд өгөгдсөн үүрэг, даалгаврыг хууль бусаар эсэргүүцэхгүй байх.

Гурав.Хугацаат цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ

3.1.Хугацаат цэргийн алба хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ ухамсарлан, үлгэр жишээгээр биелүүлж, хууль тогтоомж, Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдэд заасан хэм хэмжээг сахин биелүүлэхээс гадна дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

3.1.1.сахилга баттай байж, аливаа хэрэг, зөрчлөөс өөрийгөө болон нөхрийгөө урьдчилан сэргийлэх, дутагдлыг нуун дарагдуулахгүй байх;

3.1.2.ээлдэг зан харьцаатай байж, биеэ зөв авч явах, бусдад үлгэрлэл үзүүлэх;

3.1.3.бие бялдрын чийрэгжүүлж, хувийн болон нийтийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих;

3.1.4.эд хөрөнгийг хайрлан хамгаалж, дүрэмт хувцсыг цэвэр үзэмжтэй, дүрмийн дагуу өмсөж хэрэглэх;

3.1.5.зэвсэгтэй харьцах, байлдааны техник дээр ажиллах үед болон бусад тохиолдолд хөдөлмөр, хамгааллын аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг чанд сахих;

3.1.6.чөлөөгөөр явах хугацаанд хүндэтгэх шалтгаанаар өөрийн анги, байгууллагад хугацаандаа очих, чадахгүйд хүрвэл саатсан шалтгааныг нэн даруй харьяалах анги, байгууллагын захирагч /дарга/-д мэдэгдэх.

Дөрөв: Хариуцлага

4.1. Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг түүний эрхэлж байгаа албан тушаал, цол, ажилласан жилийг үл харгалзан шалгаж шийдвэрлэнэ.

4.2. Ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны тухай хууль болон Цэргийн сахилгын дүрэмд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр ногдуулна.

4.3. Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрсөн алба хаагчийг Төрийн албаны тухай, Цэргийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан албанаас хална.

Тайлбар: “Ноцтой зөрчил” гэж Төрийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулиар хориглосон үйл ажиллагааг зөрчсөн, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үр дагавар би болгосон, сахилгын шийтгэлгүй тооцох хугацаа өнгөрөөгүй байхад 2 буюу түүнээс дээш удаа үйлсэн үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

4.4. Ёс зүй зөрчсөн алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

Тав. Бусад

5.1. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд Дотоодын цэргийн штабын газар, хэлтсийн дарга, анги, тусгай салбарын захирагч нар өдөр тутам хяналт тавьж ажиллах үүрэгтэй бөгөөд алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.

5.2. Удирдах албан тушаалтан хариуцсан байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, арилгах, бууруулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авна.

5.3. Ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагчийг шагнаж урамшуулах, өөр албан тушаалд дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах үндэслэл болох бөгөөд дараах байдлаар урамшуулж болно.

5.3.1. хамт олны өмнө сайшааж, хувийн хэрэгт тэмдэглэх;

5.3.2. мөнгөн урамшуулал олгох;

5.3.3. боловсрол мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдах эрх олгох;

5.3.4. цалинтай амралт, сувилалд амруулна;

5.3.5. цагдаа, дотоодын цэргийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох;

5.3.6. албан тушаал дэвшүүлэх саналыг дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд уламжлах;

5.3.7. нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх.